



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01/01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн

Л.Оюун-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн

Д.Тогтохсүрэн -Улсын Их Хурлын гишүүн

Нарийн бичгийн дарга:

Б.Баасандорж -Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Д.Эрдэнэбалсүрэн -Улсын Дээд шүүхийн шүүгч

П.Нарандалай -Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга

Д.Ууганбаатар -Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Захиргаа, шинжилгээний албаны дарга

Ц.Батцэнгэл -Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор

О.Бархасбадь	-Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, хурандаа
Д.Авирмэд	-Тагнуулын ерөнхий газрын тусгай архивын дарга, дэд хурандаа
Б.Энхмаа	-Тагнуулын ерөнхий газрын цагаатгал хариуцсан ажилтан, хошууч
Д.Дашдаваа	-“Цаазлагдсан улс төрийн хэлмэгдэгчийн хүүхэд” ТББ-ын тэргүүн
Б.Батдэлгэр	-Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх
Б.Баярмаа	-Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх
О.Нарантуяа	-Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



Ш.РАДНААСЭД